



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/347

Хэрлэн сум

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн
хэлбэрээр орлуулан хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215, 2022 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрч, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоон дараагийн ээлжит цэрэг татлагын өмнө барагдуулж дуусган цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, цэргийн бүртгэлд тусгаж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ)-д даалгасугай.

3.Төлбөрийн орлогыг Хэнтий аймгийн төрийн сан банкны 100180051401 тоот дансанд төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010768